

**ИРГЭДЭЭС 2021 ОНД ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН  
АНГИ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН САНАЛ, ХҮСЭЛТ,  
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН МЭДЭЭ**



2022 оны 01 дүгээр  
сарын 08-ны өдөр

Улаанбаатар  
хот

***Нэг. Иргэд, байгууллагаас цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага,  
албан тушаалтанд гаргасан санал, өргөдөл, гомдлын  
шийдвэрлэлтийн талаар***

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын удирдах албан тушаалтанд 2021 онд иргэд, байгууллагаас 16542 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх онтой харьцуулахад 4963 нэгжээр буюу 42.9 хувиар өсчээ.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 237 буюу 1.4 хувь нь санал хүсэлт, 16035 буюу 96.9 хувь нь өргөдөл, 270 буюу 1.6 хувь нь гомдол байна.



Санал, өргөдөл, гомдлыг  
утгаар нь авч үзвэл: 1300 буюу 7.9 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 285 буюу 1.7 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 2719 буюу 16.4 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 2131 буюу 12.9 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 597 буюу 3.6 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 9510 буюу 57.5 хувь нь бусад өргөдөл, гомдол байна.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 16382 буюу 99.0 хувийг шийдвэрлэж, 160 буюу 1.0 хувь нь ажиллагаанд байна.





**Хоёр. Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаар**

2021 онд Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад иргэд, байгууллага, алба хаагчдаас 486 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирүүлснийг өмнөх онтой харьцуулахад 19 нэгжээр буюу 4,1 хувиар өсчээ.

Нийт хүлээн авсан өргөдөл, гомдол, санал хүсэлтийн 429 буюу 88.3 хувь нь өргөдөл, 50 буюу 10.3 хувь нь гомдол, 7 буюу 1.4 хувь нь санал хүсэлт байна.

**Нийт хүлээн авсан өргөдөл, гомдол, санал хүсэлт**




Иргэд, байгууллагаас цагдаагийн албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг утгаар нь авч үзвэл: 58 буюу 12.0 хувь нь ажилд орох суралцахыг хүссэн, 38 буюу 7.8 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 71 буюу 14.6 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 8 буюу 1.6 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 78 буюу 16.0 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 233 буюу 48.0 хувь нь бусад өргөдөл, гомдол байна.



**Гурав. Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах төв”-д ирсэн санал хүсэлт, гомдол, шүүмжлэлийн талаар**

2021 онд иргэдээс Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах төв”-д цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 189 санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл ирүүлсний 45 буюу 23.8 хувь нь санал хүсэлт, 117 буюу 61.9 хувь нь гомдол, 26 буюу 13.8 хувь нь талархал, 1 буюу 0.5 хувь нь шүүмжлэл байна.



Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэлийн 188 буюу 99.5 хувийг шийдвэрлэж, 1 буюу 0.5 хувьд холбогдох алба, нэгж шалгалтын ажиллагаа явуулж байна.

**Дөрөв. Иргэд, байгууллагаас цагдаа, дотоодын цэргийн алба хаагчтай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар**

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчтай холбоотой ирүүлсэн нийт 1774 өргөдөл, гомдолд 2074 алба хаагчийг холбогдуулан шалгажээ. Үүний 1697 буюу 81.6 хувийг офицер, 377 буюу 18.1 хувийг ахлагч, 4 буюу 0.1 хувийг энгийн ажилтан эзэлж байна.

Нийт зөрчлийг төрлөөр нь авч үзвэл: 327 буюу 18.4 хувь нь хууль ёс, хүний эрх чөлөө зөрчсөн, 283 буюу 15.9 хувь нь хэрэг материал дутуу шалгасан, 11 буюу 0.6 хувь нь хэргийн хугацаа хэтрүүлсэн, 98 буюу 5.5 хувь нь бусдыг чирэгдүүлж, танил тал харсан, 13 буюу 0.7 хувь нь хээл хахууль, шан харамж авсан, 415 буюу 23.3 хувь нь цагдаагийн алба хаагчийн харьцааны соёл, ёс зүй зөрчсөн, 59 буюу 3.3 хувь нь бусдын эрх чөлөөнд халдсан, 222 буюу 12.5 хувь нь ажлын хариуцлага алдсан, 89 буюу 5.0 хувь нь архидан согтуурсан, 8 буюу 0.4 хувь өмч хөрөнгө үрэгдүүлсэн, 176 буюу 9.9 хувь нь Эрүүгийн хэрэг хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль тогтоомж зөрчсөн, 6 буюу 0.3 хувь нь цалин, тэтгэвэр тэтгэмж буруу олгосон, 67 буюу 3.8 хувь нь бусад зөрчлүүд эзэлж байна.



## Зөрчлийн төрөл



Нийт хүлээн авсан **1335** өргөдөл, гомдлоос **1213 буюу 90.8** хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, **122 буюу 9.1** хувьд нь хуулийн хугацаанд шалгалтын ажиллагаа явуулж байна.

**Шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:** Нийт өргөдөл, гомдлын 39 буюу 2.9 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэх саналтай холбогдох байгууллагад шилжүүлж, 286 буюу 28.9 хувьд нь сахилгын шийтгэл оногдуулж, 788 буюу 59.0 хувьд нь цагдаагийн алба хаагчийн буруутай үйл ажиллагаа тогтоогдоогүй, 91 буюу 7.5 хувийг харьяаллын дагуу бусад байгууллагад шилжүүлсэн, 9 буюу 0.6 хувьд алба хаагчийн буруутай үйл ажиллагаа тогтоогдсон боловч хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл оногдуулах хугацаа хэтэрсэн гэх үндэслэлээр хаасан байна.

## ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТЭС